



**ХЭНТИЙ АЙМАГ
ӨМНӨДЭЛГЭР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2024 оны 08 сарын 20 өдөр

Дугаар А/164

Өмнөдэлгэр сум

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалт, Малын генетик нөөцийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.2, 16 дугаар зүйлийн 16.8.6, 16.9.2, 18 дугаар зүйлийн 18.2.3, Төсвийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.2.8 дахь заалт, сумын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 3.3.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Сумын хэмжээнд бог малын хээлтүүлэгчийг үзлэг ангилалт, ээмэгжүүлэлт, бүртгэлжүүлэлтийн ажлыг зохион байгуулахыг ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч:	Х.Саруултуяа	Хөдөө аж ахуйн тасгийн дарга
Нарийн бичгийн дарга:	Т.Одончимэг	Хөдөө аж ахуйн тасгийн мэргэжилтэн
Гишүүд:	Б.Болор-Эрдэнэ	Наран багийн Засаг дарга
	Д.Батболд	Баянзүрх багийн Засаг дарга
	А.Баянмөнх	Хэнтий багийн Засаг дарга
	Г.Нарангэрэл	Талынбулаг багийн Засаг дарга
	Ж.Энх-Амгалан	Чандган багийн Засаг дарга
	Б.Хонгорзул	Төвийн багийн Засаг дарга
	Ж.Энххуяг	Гурванбаян тосгоны захирагч
	С.Эрдэнэтуяа	"Дэлгэр Хурх" ХХК-ийн захирал
	Д.Балдиржамц	"ДэлгэрХурх" ХХК-ийн мал зүйч
	Ц.Бямбасүрэн	Сангууд хариуцсан нягтлан бодогч

2. Сумын хэмжээнд бог малын хээлтүүлэгчийг үзлэг ангилалтанд бүрэн хамруулж ашиг шимийг тогтоож, ээмэгжүүлж, бүртгэлжүүлэх ажлыг технологит

D:\disk\bichig hereg/ zahiramj

224100348

хугацаанд хийж гүйцэтгэхийг “Дэлгэр хурх” ХХК-ийн захирал (С.Эрдэнэтуяа)-д даалгасугай.

3. Үзлэг ангилалтын ажилд удирдлага, мэргэжил арга зүйгээр хангаж ажиллахыг ажлын хэсгийг ахлагч Хөдөө аж ахуйн тасгийн дарга (Х.Саруултуяа)-д үүрэг болгосугай.

4. Үзлэг ангилалтын ажилд хяналт тавьж, дүн тайлан мэдээг нэгтгэн 09 дүгээр сарын 30-ны дотор сумын удирдлагад танилцуулахыг ахлагч (Х.Саруултуяа), “Дэлгэр хурх” ХХК-ийн захирал (С.Эрдэнэтуяа) нарт даалгасугай.

5. Үзлэг ангилалтын зардлыг орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөс зарцуулахыг сангууд хариуцсан нягтлан бодогч (Ц.Бямбасүрэн)-д зөвшөөрсүгэй.



Б.ЭРДЭНЭБААТАР